



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬУЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2020 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН АГУУЛГА:

Нэг.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	
1.1.	Бодлого зорилтыг хангах ажлын хүрээнд 3-3
1.2.	Тогтоол, шийдвэр, хууль дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр:..... 3-3
1.3.	Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр: 3-3
Хоёр.ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:	
2.1.	Хэлтсээс зохион байгуулсан ажил, үйлчилгээ..... 3-5
2.2.	Онц байдлын үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ 5-6
2.3.	Албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоо,нийгмийн баталгааг хангах чиглэлээр 7-7
2.4.	Сонгуулийн арга хэмжээний үеэр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ..... 7-9
2.5.	Улсын бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойн арга хэмжээний хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ..... 9-10
Гурав. СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР	
3.1.	Ерөнхий газраас зохион байгуулсан сургалтууд:..... 10-11
3.1.	Аймаг орон нутгаас зохион байгуулсан сургалтууд 11-11
3.2.	Хэлтсээс зохион байгуулсан сургалтууд:..... 11-12
Дөрөв: ХЭЛТСИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ АЖИЛЛАХ ЧИГЛЭЛЭЭР..... 12-13	
Тав. БИЧИГ ХЭРГИЙН ЧИГЛЭЛЭЭР: 13-14	
Зургаа. ИРГЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР: 14-15	
Долоо. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР15-17	
Найм. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН чиглэлээр 17-18	
Ес. АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:	
9.1.	Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын чиглэлээр:18-18
9.2.	Хуулийн этгээдийн бүртгэлийн архивын чиглэлээр:18-19
9.3.	Иргэний бүртгэлийн архивын чиглэлээр:19-19
9.4.	Архивын бусад чиглэлээр:19-20
Арав. ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:..... 20-23	
Арван нэг. САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР: 23-28	

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

2020.12.14

Алтай хот

Нэг: ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1 Бодлого зорилтыг хангах ажлын хүрээнд

Говь-Алтай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь “Иргэнд суурилсан төрийн бүртгэлийн үнэн ой санамжийг бий болгох, төр, иргэнийг холбосон бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, төрийн бүртгэлийн үйлчилгээгээр иргэний эрхийг хангах” эрхэм зорилгыг хангахын төлөө Засгийн газар, Хууль зүй дотоод хэргийн яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар, аймгийн Засаг дарга зэрэг дээд байгууллагуудаас ирүүлсэн захирамж хөтөлбөр, тушаал, шийдвэр, чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.2 Тогтоол, шийдвэр, хууль дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр:

Үйл ажиллагаандаа Иргэний хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж, “Хөдөлмөрийн дотоод журам”, Улсын бүртгэлийн ерөнхий газраас болон орон нутгийн удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, удирдамж, чиглэл, тушаалыг мөрдлөг болгож иргэн, хуулийн этгээдэд эд хөрөнгийн улсын бүртгэл, иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг орон нутагт эрхлэн зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн 18 сум 88 багийн 57479 хүн амд бүртгэлийн үйлчилгээгээ хүргэн ажиллаж байна.

1.3 Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

Говь-Алтай аймгийн улсын бүртгэлийн хэлтэс нь УБЕГ азрын даргын 2018 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн Б/07 тоот тушаалаар батлагдсан орон тооны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн дарга 1, хяналтын улсын байцаагч 1, тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 2, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч 2, иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч 2, хуулийн этгээдийн улсын бүртгэгч 1, архивч 1, байгууллагын бичиг хэргийн эрхлэгч, нярав 1, ахлах нягтлан бодогч 1, мэдээллийн технологийн ажилтан 1, гэрээт албан хаагч 3, 18 сумын 20 улсын бүртгэгч нийт 33 албан хаагчтайгаар ажиллаж байна.

Хоёр: ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР /Зураг хавсралт-1/

2.1. Хэлтсээс зохион байгуулсан ажил:

- 2019 оны ХАСХОМ-ийг мэдүүлэх ёстой 26 албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг 2020 оны 01 сарын 20-нд багтаан сүлжээнд бүрэн шивүүлж, баталгааны маягыг гаргуулан авч баталгаажуулан хадгалсан болно. Тайлант хугацаанд авилга, ашиг сонирхолын зөрчлийн асуудлаар иргэдээс ирүүлсэн

өргөдөл, гомдол, санал хүсэлт ирээгүй мөн хөрөнгө орлогоо мэдүүлэхээс татгалзсан, хугацаа хожимдуулсан албан тушаалтан байхгүй.

- Аймгийн ЗДТГ-аас 7 хоног бүр зохион байгуулдаг агентлагын дарга нарын шуурхай хуралд хэлтсийн дарга тогтмол оролцож, хуралд хэлэлцсэн цаг үеийн мэдээ мэдээллийг албан хаагчдад мэдээлж хэвшсэн.

- Албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг хэлтсийн даргын 2020 01.15-ны өдрийн А/03 тушаалаар баталж мөрдүүлэн хуваарийн дагуу бүх албан хаагчид ээлжийн амралтаа эдэлсэн.

- 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт авлаа.

- Мөн хэлтсийн албан хаагчдад сар бүр онлайнаар хурал зохион байгуулж цаг үеийн байдал, онцгой байдлын талаар болон тулгамдаж буй асуудал, УБЕГ-ын даргаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу хэлэлцэж хэвшсэн болно.

- УБЕГ-ын “Хөдөлмөрийн дотоод журам”-д нийцүүлэн хэлтсийн дотоод журмыг шинэчлэн баталлаа.

- Тус хэлтэс нь өөрсдийн хэмжээнд туслах аж ахуй эрхэлж мөл өсгөдөг бөгөөд 5 дугаар сард халтай арвай болон тэжээлийн ургамлыг туслах аж ахуйн хэрэгцээнд, албан хаагчдын хүнсний хэрэгцээнд 1га газарт төмс, манжин, лууван гэх мэт хүнсний ногоог тус тус тариалж намрын ургац хураалтаар хураан авч албан хаагчдад олголоо.

- Хэлтсийн байрны гадна, дотор тохижилтын ажлыг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан үе шаттайгаар хийлээ. 2020 оны тайлант хугацаанд хэлтсийн гадна хүрээ гэрэл хийв. Мөн ногоон байгууламжийг сайжруулж гадна 2 хайсийг цэцэрлэгжүүлж, иргэд амрах саравч хийлээ.

- 2020 оны 05 сард албан хаагчдын ажиллах таатай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор ЭКО ХЭЛТЭС аяныг зохион явуулж, тасалгааны цэцэг 49-ийг тарьж, үйлчилгээний танхим болон коридорт байрлууллаа.

- Байгууллагын аюулгүй байдлыг хангах, иргэдэд үйлчлэх үйлчилгээг амар хялбар болгох зорилгоор тус хэлтсийн архив нь тойрч давхар танхим дамжин ордог байсныг болиулж ханыг нурааж шинэ хаалга хийж хяналтын камер байршуулав.

- Тус хэлтсийн архивын тавиурыг өөрсдөө гараараа хийж баримт байршуулах 4 тавиурыг нэмлээ.

- Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдын нэгдсэн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад зориулж тус хэлтсийн байрны 1 дүгээр давхарын танхимыг тохижуулав.

- Хүйтны улирал ирсэнтэй холбогдуулан хэлтсийн автомашины ашиглалтыг сайжруулах зорилгоор Аймгийн Засаг Тамгын газраас дулаан гражийн асуудлыг шийдвэрлүүлэв.

- Хэлтсийн даргын 2020 оны 02 сарын 03-ны өдөр баталсан төлөвлөгөөний дагуу Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор сумдын аж ахуй нэгжүүдийн судалгааг сум тус бүрээр гаргаж, хэлтсийн 2020 оны 09 сарын 03-ны №842 тоот албан бичгийн хамт удирдлагуудад нь хүргүүлэн ажиллалаа. Аймгийн хэмжээнд 1026 аж ахуйн нэгжийг эцсийн өмчлөгчөөр бүртгэлд хамруулахаас эцсийн өмчлөгчөөр 378 аж ахуйн нэгж эцсийн өмчлөгчөө мэдүүлж 36,9 хувьтай байна.

- Хэлтсийн албан хаагчдын шагналын судалгааг шинэчлэн гаргаж, Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн чиглэлийн дагуу ажилдаа идэвхи зүтгэлтэй ажиллаж байгаа албан хаагчдыг хамт олны хурлаар хэлэлцэн шагналын материалыг хугацаанд нь УБЕГ-т хүргүүлсэн.

- Байгууллагын үйлчилгээний стандартыг мөрдөж хэвшүүлэхэд онцгойлон анхаарч Хэлтсийн даргын зөвлөлийн гишүүд нь албан хаагчдын харьцаа, хувцаслалт, ажлын цаг ашиглалтанд хуваарь гарган хяналт тавьж стандартыг хэвшүүлэн ажиллаж байна. Хяналтын ажлын явцыг Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн албан хаагчдад зөвлөмж хүргүүллээ.

- Мөн төрийн албаны цалингийн нэгдсэн системийн программаар албан хаагчдын цалинг 9-р сараас эхлэн олгодог боллоо.

Онлайн сум:

- "Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох" төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2020 оны 08 дугаар сарын 25-наас 2020 оны 09 сарын 06-ны хооронд Шарга, Төгрөг, Бугат, Дарив, Тонхил, Хөхморьт, Баян-Уул, Жаргалан, Дэлгэр, Гуулин сумдыг бүртгэлийн нэгдсэн онлайн сүлжээнд холбох ажлыг хэлтсийн мэдээллийн технологийн ажилтан, жолоочийн хамт амжилттай холбож хэвийн ажиллагаанд орууллаа.

Ингэснээр тус аймгийн 18 сум, 1 баг онлайн сүлжээнд холбогдохоос 17 сум, 1 баг сүлжээнд бүрэн холбогдлоо. Холбогдоогүй сум болох Алтай сум нь шилэн кабель татагдаагүйн улмаас холбох ажил хийгдээгүй болно.

Хамтын ажиллагаа:

-Тус хэлтэс нь аймгийн Засаг даргын Тамгын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Цагдаагийн газар, Тагнуулын хэлтэс, Татварын хэлтэс зэрэг байгууллагуудтай үйл ажиллагааны чиглэлээр тогтмол хамтарч ажиллаж байна. Тайлант жил эдгээр байгууллагуудаас нийт 362 хариутай бичиг ирсэнийг бүртгэж хариуг хугацаанд нь шийдвэрлэлээ. Мөн хамтарсан хурал, хэлэлцүүлэг зохион байгуулан хамтран ажилласан байна.

- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн "Архигүй-Алтайчууд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх аянд нэгдэж "Архигүй хамт олон" зорилтын хүрээнд ажлуудыг зохион байгуулсан.

- Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ял эдлэж байгаа иргэн Н-ийн хүсэлтийн дагуу гэрлэлтийн бүртгэлийг хийж гэрчилгээг гардуулан өглөө.

- Аймгийн "Жаргалант-Алтай" өрхийн эмнэлэгтэй хамтран ажиллаж "Хамтын ажиллагааны төлөвлөгөө"-ний дагуу 2020 оны 12 сарын 09-ны өдөр хэлтсийн өндөр насны тэтгэвэрт гарсан 2 ахмад настан болон хэлтсийн аймгийн төвийн 14 албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт оруулан томуугийн эсрэг вакцинд хамруулав. /Төлөвлөгөөний дагуу сумдын бүртгэгч нарыг бүрэн хамруулах ёстой байсан боловч онц байдал зарласантай холбогдуулан сумдын бүртгэгч нар хамрагдаж чадаагүй/

2.2. ОНЦ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

/Зураг хавсралт-2/

Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн болон бүрэн шилжүүлсэн хугацаанд Улсын онцгой комисс, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Аймгийн онцгой комиссоос ирүүлж буй заавар, зөвлөмж, чиглэлийн дагуу тухай бүр нь арга хэмжээ авч ажиллаж байна. Үүнд:

- Эрүүл мэндийн Яам, аймгийн Онцгой комиссоос гаргасан эрүүл мэндийн зөвлөгөө, халдвараас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөмж бүхий сурталчилгааны зурагт хуудсыг байгууллагын хаалга, үйлчилгээний танхим, үйлчилгээ үзүүлж буй цонхонд байршууллаа.

- ЭМЯ-аас гаргаж буй видео зөвлөмжүүдийг хэлтсийн үйлчилгээний зааланд дэлгэц байршуулан тогтмол явуулж иргэдэд хүргэж байна.

- Албан хаагчдад тус бүр гар халдваргүйжүүлэгч санитол, үйлчилгээ үзүүлэх цонх бүрт гар ариутгагч шингэнийг байрлуулж хэлтсийн нөөцөнд гар ариутгагч авч, дууссан албан хаагчид болон үйлчилгээний цонхны ариутгагч шингэнийг тогтмол цэнэглэж байна.

- Алсын зайнаас халуун хэмжих багажийг хэлтэст авч албан хаагчдыг өглөө ажилд ирэх болон ажлаас явах үед биеийн халууныг нь үзэж тэмдэглэл хөтлөн ажиллаж байна.

- Хэлтсийн захиргаанаас улсын бүртгэлийн хэлтсийн үйлчилгээний заал, албан хаагчдын өрөө, архив, коридор, шат гээд байрны бүхий л хэсгүүдэд аймгийн мэргэжлийн байгууллага болох “ЗООНОЗ”-ын өвчин судлалын албаар сард 2 удаа ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэн ажиллаж байна.

- Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Нэг төрийн албан хаагч 3 маск” хандивын аянд нэгдэж нийт 102 маскийг хандивлав.

- Хэлтсийн албан хаагч тус бүрт сар бүр 20 ширхэг нэг удаагийн амны хаалтыг олгож байна.

- Мөн албан хаагч бүрт 2 сар тутам дархлаа дэмжих үүднээс дархлааны витамин, аарц, чацаргана жимсийг олгож байна.

- Эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу тогтмол халуун шингэн юм уулгах зорилгоор албан хаагчдын өрөө бүрт суурин ус буцалгагч байрлуулсан.

- Мөн үйлчилгээний зааланд зай байрьж зогсох санамжийг наасан.

- “Маскаа зүүцгээе” “зурган болон, видео чейленж”-д нэгдэж Улсын бүртгэлийн хэлтсүүдээс Баян-Өлгий аймаг, Сүхбаатар дүүрэг, Налайх дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүдийг дуудаж, уг чейленжийг аймагтаа эхлүүлж аймгийн ЗДТГ, Цагдаагийн газар, Нийгмийн даатгалын хэлтсүүдийг дуудаж маск зүүх аян иргэдэд сурталчилж ажилласан.

- Хэлтсийн үйлчилгээний танхимд үйлчилгээ үзүүлж байгаа албан хаагчид болон үйлчлүүлэгч иргэдийн хорио цээрийн дэглэмийг ягштал баримтлуулах, үйл ажиллагаанд нь байнгын хяналтыг тавих зорилгоор 2 албан хаагчийг томилон үйлчилгээ авч байгаа иргэн бүрийн халууныг зайнаас халуун хэмжих багажаар үзэж, бүртгэл хөтлөн гарыг нь ариутгуулан маскгүй үйлчлүүлэгч иргэнийг маскаар ханган дотогш нэвтрүүлж байна.

- Хэлтсийн даргын баталсан хуваарийн дагуу албан хаагчдыг хариуцлагатай жижүүрт томилон ажиллуулж, цаг үеийн мэдээг холбогдох газар, хэлтэст хүргүүлэн ажиллаж байна. Мөн зайлшгүй улсын бүртгэлийн үйлчилгээ авах иргэдийг цаг товлон хүлээн авч үйлчилгээг үзүүлж байна.

- Цар тахлын үеийн байршлын мэдээлэл болох байгууллагын QR кодыг qr.119.mn хаягт бүртгүүлэн авч байгууллагын хаалганд наасан иргэдийг уншуулж орохыг сануулан ажиллаж байна.

2.3. АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ БОЛОЛЦОО, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР:

-Тус хэлтэс нь 2019 онд Аймгийн ЗДТГ-ын 3-р байранд нүүн орж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Хуучин байрлаж байсан өөрийн эзэмшлийн орон сууцны 1 давхарт байрлах 3 өрөөг сумдын бүртгэгч нарын хандиваар тохижуулан /холын сумдын бүртгэгч нар сургалт семинарт ирэхдээ байрлах буудал, албан хаагчдын чөлөөт цагийг өнгөрүүлэх фитнес, шатар, даам гэх мэт спортын арга хэмжээ явуулах/ ашиглаж байна.

-Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны Б/156 тоот тушаалаар 2020.07.01-ээс эхлэн 17 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан , 8 албан хаагчдын зэрэг дэвийг шинээр тус тус олгууллаа.

- Хэлтсийн даргын 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн Б/01, Б/02 тоот тушаалаар төрийн захиргааны 25, төрийн үйлчилгээний 4, гэрээт 3, нийт 32 албан хаагчдын цалинг шинэчлэн гаргасан.
- Хэлтсийн даргын 2020 оны 07 дүгээр сарын 01-ны өдрийн Б/03, Б/04 тоот тушаалаар 2 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг ахиулан олгосон.
- УБЕГ-ын даргын тушаалаар Есөнбулаг, Тайшир сумдын бүртгэгчийн ажил үүргийг хавсран гүйцэтгэж буй 2 албан хаагч үндсэн цалингийн 20 хувийн нэмэгдлийг авч ажил үүрэг хавсран гүйцэтгэж байна.
- УБЕГ-аас өгсөн захиалгын дагуу Удирдлагын академиас зохион байгуулсан Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтанд 2020.05-р сард Хэлтсийн дарга Г.Чүлтэмжамц хамрагдаж сертификатаа авсан.
- Аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран 2020.12.07-ны өдөр хэлтсийн өндөр настан болон аймгийн төвийн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, томуугийн эсрэг вакцин хийлгүүллээ.
- Дэлхий нийтийг хамарсан ковид 19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, халдварт өвчнөөс албан хаагчдыг хамгаалах зорилгоор төгрөгийн үнэ бүхий амны хаалт, гар ариутгагч, бээлий олгож, мэргэжлийн байгууллагаар ажлын байрыг 3 удаа ариутгууллаа.

2.4. СОНГУУЛИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮЕЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ: /Зураг хавсралт-3/

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг нийслэл,сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль,түүнтэй холбоотой хууль тогтоомжийн дагуу бэлтгэл ажлыг хангаж амжилттай зохион байгуулан ажиллав.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн ажлын хүрээнд:

- 2020 оны 02 сарын 01-ны өдрөөс хуулийн дагуу улс орон даяар шилжилт хөдөлгөөнийг зогсоосон.

- УБЕГ-ын 2020.05.19-ний өдрийн №5/4911 тоот албан бичгийн дагуу 2020 оны 06 сарын 04-ний өдрөөс сонгогч шилжих журмын дагуу материалуудыг хүлээн

авч 2020 оны 06 сарын 10-ны өдөр сонгогчийн шилжилтийг хааж жагсаалт, тайлан мэдээг УБЕГ-т хүргүүлж зөрчил, дутагдалгүй ажилласан.

- 2020 оны 05 сарын 26-ны өдөр Сонгогчийн нэрсийн жагсаалтыг хэвлэж, 2020 оны 05 сарын 26-наас 2020 оны 05 сарын 31-ний өдрүүдэд тус аймгийн 18 сумын сонгуулийн хэсгийн хороодод хүлээлгэн өгөх ажлын хэсгийг хэлтсийн даргын А/08 тоот тушаалаар томилон хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

- 2020 оны ээлжит сонгуулийн санал авах байрын дэргэд ажиллах Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад хэрэглэгдэх компьютер, тоног төхөөрөмжийг 2020 оны 06 сарын 01-ний өдрөөс 2020 оны 06 сарын 05-ны өдрүүдэд аймгийн Тагнуулын хэлтэс, Цагдаагийн газрын хамгаалалтанд Улсын бүртгэлийн ерөнхий газраас хүлээн авч аймгийн Тагнуулын хэлтсийн байранд байрлуулж ажилласан.

- 2020 оны 06 сарын 13-аас 2020 оны 06 сарын 14-ний өдрүүдэд итгэмжлэгдсэн ажилтнуудын програмын сургалтыг хийсэн. /дэлгэрэнгүйг “Сургалтын үйл ажиллагаа” сэдэвт байршуулав/

- 2020.06.17-ны өдрөөс 2020.06.18-ны өдрүүдэд тус аймгийн 18 сумын сонгуулийн хэсгийн хороонд сонгогчийн нэрийн жагсаалт, компьютер хүлээлгэн өгөх ажлын хэсгийг хэлтсийн даргын А/10 тоот тушаалаар томилж ажиллуулав.

- 2020.06.24-ны өдөр Монгол Улсын их хурлын сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагаас хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу ажиллаж ямар нэгэн алдаа зөрчил гаргаагүй. Сонгуулийн ирцийн мэдээг цаг хугацаанд нь хүргүүлж ажиллалаа.

- Сонгуулиар ашиглагдсан компьютер тоног төхөөрөмжийг хуваарийн дагуу 2020 оны 06 сарын 27-ны өдөр УБЕГ-т хүргүүлэх ажлыг хэлтсийн Мэдээлэл технологийн ажилтан, Цагдаа, Тагнуулын байгууллагын албан хаагчдын хамгаалалтан дор актаар хүлээлгэн өгсөн.

Аймаг нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн ажлын хүрээнд:

- 2020 оны 08 сарын 15-ны өдрөөс хуулийн дагуу улс орон даяар шилжилт хөдөлгөөнийг зогсоосон.

- 2020 оны 09 сарын 17-ны өдөр Сонгогчийн нэрсийн жагсаалтыг хэвлэж, Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсэгт заасны дагуу 2020 оны 09 сарын 17-ноос 2020 оны 09 сарын 20-ны өдрүүдэд тус аймгийн 18 сумын сонгуулийн хэсгийн хороодод хүлээлгэн өгөх ажлын хэсгийг хэлтсийн даргын баталсан төлөвлөгөөний дагуу хугацаанд нь хүргүүлэн ажиллаж тайланг холбогдох газарт нь хүргүүлж ажилласан.

- Аймаг, Нийслэл, Сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль”-аар улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудын ашиглах компьютер, принтер, бусад тоног төхөөрөмжийг авах ажлаар 2020 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Улаанбаатар хот, Улсын бүртгэлийн ерөнхий газраас аймгийн Тагнуулын хэлтсийн ажилтан, хошууч Д.Пүрэвням, Цагдаагийн газрын ажилтан дэд ахлагч Жүгдэрнамжил нарын хамгаалалтан дор лацыг нэг бүрчлэн тулгаж хүлээн авч зөөвөрлөн аймгийн Тагнуулын хэлтсийн байранд байрлуулсан.

- Итгэмжлэгдсэн ажилтнуудыг “Эрх зүйн мэдээллээр хангах онлайн сургалт”-ыг 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр 10:00-15:00 цагт зохион байгуулсан

- 2020.10.02-ны өдрөөс 2020.10.03-ны өдрүүдэд итгэмжлэгдсэн ажилтнуудын програмын сургалтыг хийсэн. /дэлгэрэнгүйг “Сургалтын үйл ажиллагаа” сэдэвт байршуулав/

- 2020.10.15-ны өдөр ИТХ-ын сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагаас хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу ажиллаж ямар нэгэн алдаа зөрчил гаргаагүй. Сонгуулийн ирцийн мэдээг цаг хугацаанд нь хүргэж ажиллалаа.

- Сонгуулиар ашиглагдсан компьютер тоног төхөөрөмжийг хуваарийн дагуу 2020 оны 10 сарын 28-ны өдөр УБЕГ-т хүргүүлэх ажлыг хэлтсийн Мэдээлэл технологийн ажилтан, Цагдаа, Тагнуулын байгууллагын албан хаагчдын хамгаалалтан дор актаар хүлээлгэн өгсөн.

2.5. УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГА ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ 80 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ /Зураг хавсралт-4/

- Тус хэлтсээс Улсын бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөнд оруулах саналыг бүх албан хаагчдаас бичгээр авч нэгтгэн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2020.10.22-ны өдрийн А/25 тоот тушаалаар 13 заалт бүхий төлөвлөгөө батлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Ерөнхий боловсролын 1,2,3,4 дүгээр сургуулиудын ахлах ангийн сурагчдад “Улсын бүртгэл-Хэрэгцээ шаардлага” сэдвийн хүрээнд Улсын бүртгэлийн байгууллагын чиг үүрэг, иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний талаар сургалт явуулж АХА тэмцээнийг зохион байгууллаа. Нийт 560 гаруй багш сурагч хамрагдлаа.

- Аймгийн Хөдөлмөр Халамж үйлчилгээний газартай хамтран нийгмийн эрсдэлтэй бүлгийн бичиг баримтаа гээсэн болон 25,45 насны сунгалтаа хийлгээгүй 13 иргэнийг бичиг баримтжууллаа.

- Тус хэлтсийн Хяналтын улсын байцаагч Д.Оюунчимэгээр ахлуулсан ажлын хэсэг ойн арга хэмжээний хүрээнд Улсын бүртгэлийн байгууллагын “НЭЭЛТТЭЙ ХААЛГА”-ны өдрийг 2020.11.09-ны өдрөөс 11 сарын 14-ны өдрүүдэд Шарга, Төгрөг, Тонхил сумдад зохион байгуулж онлайнд холбогдсон ач тусыг иргэдэд таниулан 3 төрлийн бүртгэлийг сумд нь хийж бүртгэлийн үйл ажиллагааг иргэдэд сурталчилан ажиллалаа. Дээрхи сумдад ажиллах хугацаандаа нийт 220 гаруй иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч эд хөрөнгийн 32, мэдүүлэг, авч 21 гэрчилгээ олгосон, хуулийн этгээдийн чиглэлээр 19 мэдүүлгийг иргэн, хуулийн этгээдээс хүлээн авч газар дээр нь асуудлыг шийдвэрлэн ажиллалаа

- Тус хэлтсийн албан хаагчид ойг угтаж хийгдэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан “Сайн үйлсийн аян”-ны хүрээнд хүнд өвчнөөр өвдсөн Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын улсын бүртгэгч Г.Цоггэрэлийн эмчилгээний зардалд 300.000 төгрөгний хандивыг өглөө. Мөн Шарга, Төгрөг сумын эрсдэлтэй бүлгийн иргэн Д.Мөнхөө /ДП68120810/, О.Буянбат /ДИ54121111/ нарын цахим үнэмлэхний сунгалтын үйлчилгээний хөлс, иргэн О.Буянбат/ДИ54121111/-ын кадастрын зургийн үнэ НИЙТ 46000 төгрөгийг тус тус тушааж улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүллээ.

- Улсын бүртгэлийн хэлтсээс ойг угтаж хийгдэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2020 онд хийсэн ажлаа иргэдэд сурталчлан таниулах, төрийн

үйлчилгээг нэг дороос хүргэх,иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах зорилгоор 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Төрийн байгууллагуудтай хамтран “ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР” арга хэмжээг зохион байгуулж “АЗТАЙ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ” шалгаруулан гарын бэлэг гардууллаа.

Гурав: СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Тус хэлтсийн албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл мэндийг хамгаалах зэрэг ажлуудын хүрээнд 2020 онд явагдах сургалт, сурталчилгааны төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний дагуу ажлуудыг зохион явуулж байна.

3.1. Ерөнхий газраас зохион байгуулсан сургалтууд:

УБЕГ-аас танхимаар зохион байгуулсан сургалтууд:

- 2020 оны 06 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын ахлах бүртгэгч Л.Өнөртуяагаар ахлуулсан сургалтын баг ирж Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн санал авах байрын дэргэд ажиллах Улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнуудад “Ирц бүртгэлийн программын сургалт”-ыг зохион байгуулж тус сургалтанд 90 итгэмжлэгдсэн ажилтан, тус хэлтсийн шуурхай багийн бүрэлдэхүүн хамрагдав.

- 2020 оны 10 дугаар сарын 01, 02-ны өдрүүдэд Улсын бүртгэлийн ерөнхий газрын ахлах мэргэжилтэн Амаржавхлангаар ахлуулсан сургалтын баг ирж Аймаг,нийслэл,сум,дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулийн санал авах байрын дэргэд ажиллах Улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнуудад “Ирц бүртгэлийн программын сургалт”-ыг зохион байгуулж тус сургалтанд 90 итгэмжлэгдсэн ажилтан, тус хэлтсийн албан хаагчид хамрагдлаа.

УБЕГ-аас онлайнаар зохион байгуулсан сургалтууд:

- 2020 оны 01 сарын 04-ний өдөр Эцсийн өмчлөгчийн бүртгэлийн талаар зохион байгуулсан онлайн сургалтанд хэлтсийн хуулийн этгээдийн улсын бүртгэгч З.Цэндсүрэн

- 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан “Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудлаар” онлайн сургалт зохион байгуулж Хэлтсийн дарга Г.Чүлтэмжамц, Бичиг хэргийн ажилтан, нярав Б.Тогтохбаяр нар

- 2020 оны 03 сарын 06-ны өдөр УИХ-ын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд УБЕГ-аас албан хаагчдад сонгуулийн тухай хууль тогтоомжийг таниулах, зөвлөмж чиглэл өгөх онлайн сургалтанд хэлтсийн хэлтсийн дарга, Улсын ахлах бүртгэгч, ахлах нягтлан бодогч нар

- 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан Албан хэрэг хөтлөлтийн онлайн сургалтанд тус хэлтсийн Бичиг хэргийн ажилтан, нярав Б.Тогтохбаяр, гэрээт ажилтан М.Бат-Эрдэнэ нар

- 2020 оны 04 дүгээр сарын 15- 16-ны өдрүүдэд зохион байгуулсан Улсын бүртгэлийн байгууллагын удирдах ажилтны сургалтанд хэлтсийн дарга, Улсын ахлах бүртгэгч, Хяналтын Улсын байцаагч, Ахлах нягтлан бодогч нар

- 2020 оны 04дүгээр сарын 22-ны өдөр УБЕГ-аас зохион байгуулсан Иргэний Улсын ахлах бүртгэгч нарт зориулсан онлайн сургалтанд хэлтсийн иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, Улсын ахлах бүртгэгч Я.Арвижих

- 2020 оны 04 сарын 30-ны өдөр зохион байгуулсан Хуулийн этгээдийн Улсын бүртгэгч нарт зориулсан онлайн сургалтанд тус хэлтсийн Хуулийн этгээдийн Улсын бүртгэгч З.Цэндсүрэн

- 2020 оны 05 сарын 13-14-ний өдрүүдэд зохион байгуулсан Хяналтын Улсын байцаагч нарын нэгдсэн сургалтанд хяналтын улсын байцаагч Д.Оюунчимэг

- 2020 оны 05 сарын 26-ны өдөр зохион байгуулсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” сургалтанд хэлтсийн дарга, ахлах бүртгэгч нар, хяналтын Улсын байцаагч нар

- 2020 оны 08 сарын 11-ний өдөр зохион байгуулсан хэлтсийн дарга нарын хуралд хэлтсийн дарга хамрагдсан.

- 2020 оны 08 сарын 22-ны өдөр зохион байгуулсан Хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарт зориулсан сургалтанд хэлтсийн ХЭ-ын улсын бүртгэгч хамрагдсан.

- 2020 оны 09 сарын 04-ний өдөр зохион байгуулсан “Чиглэл өгөх” цахим сургалтанд хэлтсийн дарга, улсын ахлах бүртгэгч, хяналтын улсын байцаагч нар хамрагдав.

- 2020 оны 09 сарын 14-ний өдөр зохион байгуулсан цахим сургалтанд хэлтсийн дарга, улсын ахлах бүртгэгч нар хамрагдав.

- 2020 оны 09 сарын 15-ны өдөр Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулийн санал авах байранд ажиллах Улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнуудад “Эрх зүйн цахим сургалт”-ыг зохион байгуулж тус сургалтанд 87 итгэмжлэгдсэн ажилтан, тус хэлтсийн шуурхай багийн бүрэлдэхүүн хамрагдав.

- 2020 оны 09 сарын 18-ны өдөр зохион байгуулсан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зориулсан сургалтад хэлтсийн Эд хөрөнгийн тасгийн ахлах бүртгэгч, улсын бүртгэгч нийт 3 албан хаагч хамрагдсан.

- 2020 оны 11 сарын 04-ны өдөр зохион байгуулсан Вэбсайт цахим сургалтанд хэлтсийн мэдээллийн технологийн ажилтан хамрагдсан.

- 2020 оны 11 сарын 10-ны өдөр Иргэний улсын бүртгэгч нарт зориулсан сургалтанд хэлтсийн иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч нар тус тус хамрагдав.

3.2. Аймаг орон нутгаас зохион байгуулсан сургалтууд:

- 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр аймгийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан “Гал түймрийн аюул, ослоос урьчилан сэргийлье” сэдэвт сургалтанд хэлтсийн нийт хамт олон хамрагдав.

- Аймгийн онцгой комиссоос зохион байгуулсан гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулилтын үйл ажиллагаанд хэлтсийн албан хаагчид бүрэн хамрагдаж анхан шатны зохих мэдлэгийг авсан.

- 2020 оны 10 сарын 13-ны өдөр Албан хаагчдад Аймгийн ГБХЗХГ-ын дарга Ч.Цээпилмаа, сэтгэл зүйч Д.Пүрэвсүрэнтэй хамтран “Ажлын байран дахь стресс, түүнийг бууруулах арга” сэдвээр 3 цагийн сургалтыг зохион байгуулсан.

- 2020 оны 12 сарын 11-ны өдөр Аймгийн Татварын хэлтэстэй хамтран E-barimt апплекэйшин, QR код, нөөтийн баримтын талаар сургалтыг хэлтсийн нийт 16 албан хаагчдыг хамруулан зохион байгууллаа.

3.4. Хэлтсээс зохион байгуулсан сургалтууд:

- Аймгийн Тагнуулын хэлтэстэй хамтарч 2020.04.14-ний өдөр тагнуулын ажилтан, ахмад Д.Пүрэвням Гэмт хэрэг, түүний хор уршиг, сүлжээний гэмт

хэрэгийнталаар 1 цагийн онлайн сургалт хийлээ. Тус сургалтандхэлтсийн 15албан хаагч хамрагдав.

- 2020 оны 05 дугаар сарын 19-ны өдөр МонголУлсынИхХурлынсонгуулийн тухай хууль, түүнтэй холбоотой хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх, санал авах өдөр сонгогчийн бүртгэлийг нягтлан шалгахтай холбоотой анхаарах асуудлуудын талаар болон эрх зүйн мэдлэг олгох цахим сургалтыг зохион байгуулж 91 итгэмжлэгдсэн ажилтан, шуурхай багийн албан хаагчид бүрэн хамрагдлаа.

- 2020 оны 08 дугаар сар 10-12-ны өдрүүдэд Есөнбулаг сумын 10 багийн засаг дарга, нийгмийн ажилтнуудад цахим үнэмлэх болон бүртгэлийн хугацаа, 16 нас хүрээд анх удаа авч байгаа болон 25,45 насны сунгалт, эд хөрөнгө өмчлөх эрхийн талаар сургалтуудыг зохион байгуулсан

- 2020 оны 10 сарын 03-ны өдөр Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулийн санал авах байранд ажиллах Улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнуудад Төрийн нууцын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, бусад хууль тогтоомжоор Аймгийн тагнуулын хэлтсийн ажилтан З.Бат-Орших, Цагдаагийн газрын хэв журам хамгаалах тасгийн дарга Л.Гантулга нартай хамтран сургалт зохион байгуулж тус сургалтанд 87 итгэмжлэгдсэн ажилтан, тус хэлтсийн албан хаагчид хамрагдав.

- 2020 оны 10 сарын 30-ны өдөр тус хэлтсээс онлайн системд холбогдсон 17 сум 1 тосгоны бүртгэгч нарт онлайн порграмын цахим сургалтыг зохион байгуулж, программд нэвтэрч бүртгэл хийх эрхийг Иргэний бүртгэлийн газарт хандан нээлгүүлсэн.

Дөрөв: ХЭЛТСИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ АЖИЛЛАХ ЧИГЛЭЛЭЭР: /Зураг хавсралт-5/

Цахим хаяг: <https://govi-altai.burtgel.gov.mn/>

Фэйсбүүк хаяг: /Говь-Алтай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс/

Фэйсбүүк хаяг: /байгууллагын албан хаагчид зөвхөн орох, дотоод албан бичиг, мэдээ мэдээлэл солилцох/: [/GAA-n UBHeltes/](#)

Цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан мэдээлэл.

➤ Ерөнхий газраас нэгдсэн цахим хуудсыг ашиглахаар болсны дагуу доторх мэдээ мэдээллийг бүрэн шинэчилж ашиглаж байна.

➤ Бүртгэлийн үйлчилгээнд нийтээр дагаж мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомжийг байгууллагын хуулийн самбарт байршуулсан бөгөөд хууль журмуудыг хэвлэж гарын авлага болгон бүртгэгч нарт өгөхөөс гадна дотоод сүлжээ, [GAA-n UBHeltes](#) фэйс хаягуудад байрлуулсан ажилладаг.

➤ Хэлтсийн даргын иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг байгууллагын ил тод байдлын самбар болон цахим хуудасны “Холбоо барих” цэсд байршуулж, хэлтсийн даргын өрөөний үүдэнд байрлуулсан болно.

➤ Өргөдөл гомдол, санал хүсэлт хүлээн авах ажилтны албан тушаал, нээлттэй утас, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаарх мэдээ мэдээллийг цахим хуудасны “Хэрэглэгч танд” булангийн “Өргөдөл гомдлын шийдвэрлэлт” цэст байрлуулсан.

➤ Улсын бүртгэлийн үйлчилгээний статистик мэдээ, мэдээллийг байгууллагын ил тод байдлын самбарт байрлуулсан байнга шинэчилж, цахим

хуудасны “Хэрэглэгч танд” цэсд мөн байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар дамжуулан тогтмол мэдээллэн ажиллаж байна.

➤ Төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйл, ёс зүйн дүрэм зэргийг байгууллагын үйлчилгээний зааланд байрлуулж, Албан хаагч нарт мөрдүүлж, хэвшүүлж байна.

➤ Нийтэд хамаарал бүхий байгууллагын хүний нөөцийн тухай мэдээлэл, бүтэц орон тооны мэдээлэл зэргийг байгууллагын ил тод байдлын самбарт байрлуулсан бөгөөд цахим хуудасны “Ил тод байдал” цэсээр дамжуулан иргэдэд хүргэж ажиллаж байна.

➤ Нийтэд хамаарал бүхий төсөв санхүүгийн тухай мэдээ мэдээллийг байгууллагын ил тод байдлын самбарт байрлуулан тогтмол шинэчилдэг бөгөөд цахим хуудасны “Шилэн данс” цэсд мөн Санхүүгийн ил тод байдал цэст тус тус байрлуулан ажиллаж байна. Мөн хэлтсийн төв контор болон үйлчилгээний зааланд шилэн дансны самбарыг байршуулан иргэдэд төсөв санхүүгийн талаар байнга ил тод мэдээллэж байна.

Сурталчилгааны чиглэлээр:

➤ Хэлтсийн албан ёсны цахим хуудас, фэйсбүүк хаягаас гадна аймгийн “Миний нутаг” ТВ, “Алтай” ТВ, “Алтай” радио, “Алтайн мэдээ” сонингоор дамжуулан бүртгэлийн үйлчилгээний талаарх мэдээллээ байнга иргэдэд сурталчилж ажилладаг.

➤ Мөн үйлчилгээний зааланд иргэдэд мэдээлэл хүргэх үүднээс байгууллагын LCD зурагтыг байрлуулан байнга мэдээллийг шинэчилж, цар тахлын цаг үеийн мэдээ мэдээлэл холбогдох шторк ведиог байнга явуулж иргэдэд анхааруулга сэрэмжлүүлэг болгон ажиллаж байна.

➤ Цар тахлын үед иргэдийг улсын бүртгэлийн байгууллагыг зорихгүйгээр цахимаар үйлчилгээ авах талаар заавар зөвлөгөө мэдээ мэдээллийг байгууллагын цахим хаяг, фэйсбүүк хаягаар дамжуулан хүргэх мөн утсаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна.

➤ Тасаг нэгжийн болон бүртгэгч бүрийн өмнө танилцуулга, ажлын чиг үүрэг, албан тушаалыг харуулсан танилцуулгыг бэлдэж иргэдийн ямар үйлчилгээг хэнээс яаж авах талаар мэдээллийг авах боломжийг бүрдүүлсэн мөн цар тахлын үед иргэдийг шуурхай үйлчилгээ авах боломжийг ханган 2 угтах ажилтан гаргаж ажиллаж байна.

Үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

➤ Албан хаагчдын компьютерийн плаш оролтуудыг бүрэн хаасан. Мөн аюулгүй байдлын санамжийг компьютер болгон дээр наасан.

➤ Албан хаагчдын ашиглаж байгаа компьютер болон програмуудын нууц үгийг 14 хоногоос 1 сар дотор заавал солиулж, солиулсан талаар бүртгэл хөтлөн гарын үсэг зуруулан ажиллаж байна.

➤ Байгууллагын архив, сүлжээ сервер болон үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор үйлчилгээний заал, коридор, архивын гадна дотор хаалга, сургалтын заал зэрэгт камер байрлуулан ажиллаж байна.

Тав. БИЧИГ ХЭРГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Тус хэлтсийн бичиг хэргийн ажилтан нь ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үйлчилгээг хууль журмын дагуу хийж, албан хэрэг хөтлөлт, бичиг баримтын эргэлт, шийдвэрлэлт, хадгалалт хамгаалалтад байнгын хяналт тавин ажиллалаа.

Тухайн хугацаанд хэлтсээс нийт 1162 албан тоотыг явуулсанаас хууль УБЕГ-т 383, хяналтын байгууллагад 392, Аймгийн ЗДТГ, ИТХ-д 25, бусад албан байгууллагад 358 албан бичгийг хүргүүлсэн байна.

Мөн 190 бичиг ирсэнээс УБЕГ-аас 61, хууль хяналтын байгууллагаас 23, Аймгийн ЗДТГ, ИТХ-аас 9, бусадбайгууллагаас 97 бичиг ирсэн байна.

Мөн хэлтэст нийт 455 хариутай бичиг ирсэнээс Хууль, хяналтын байгууллагаас 350, аймгийн ЗДТГ, ИТХ-аас 12, УБЕГ-аас 18, бусад байгууллагаас 73 албан бичиг ирсэнийг холбогдох албан хаагчдад даргын цохолтоор хүргүүлж 100 хувь шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд хэлтэст нийт 72 өргөдөл ирсэнээс 57 өргөдлийг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэж, 5 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байгаа талаар батлагдсан маягт, хүснэгтийн дагуу нэгтгэж тайлан мэдээг УБЕГ болон аймгийн ЗДТГ-т тус тус хүргүүлж ажилласан. Үүнд: Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үндсэн үйл ажилгаатай холбоотой асуудлаар 6, Бүртгэлийн хяналтын үндсэн үйл ажилгаатай холбоотой асуудлаар 62, Ажлын байр, болон албан хаагчидтай холбоотой асуудлаар 1, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 1 өргөдөл тус тус ирсэн байна.

Зургаа. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

2020 онд шинэ төрсөн хүүхэд 1315, эцэг тогтоолт 52, гэрлэлт 280, гэрлэлт цуцлалт 30, үрчлэлт 30, овог нэр, нэр өөрчилсний бүртгэл 61, нас баралт 280, иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлээр бусад аймаг хотоос шилжин ирсэн 357, аймаг доторхи шилжилт хөдөлгөөнөөр 1422 иргэний бүртгэлийг бүртгэж, хянан баталгаажуулж онлайн санд оруулсан.

Мөн иргэний шинэчилсэн бүртгэлд шинээр хамрагдсан 762, иргэний үнэмлэхний хугацаа дууссан 1390, бичиг баримтаа хаяж үрэгдүүлсэн 607 иргэнд иргэний үнэмлэхийг шинээр болон дахин хэвлэн олгож, гадаад паспорт авах 190 иргэний хүсэлтийг хүлээн авч гадаад паспортыг хэвлүүлэн иргэдэд олгосон байна.

Монгол Улсын Их хурлын сонгууль, аймаг нийслэл сум дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх УБЕГ-ын ажлын төлөвлөгөөний дагуу орон нутагт хийж хэрэгжүүлэхээр тусгагдсан дараахь ажлуудыг хэрэгжүүлж ажилласан.

ҮҮНД:

1. УИХ-ын сонгууль, аймаг нийслэл, сум дүүргийн сонгуулийн хуульд тус тус заасан хугацаанд болон УБЕГ-ын даргын тушаалын дагуу иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хуулийн хугацаанд нь бүртгэн баталгаажуулж, 2 шатны тайлан мэдээг нэгтгэн гаргаж илтгэх хуудсаар УБЕГ-ын ИБГ-т хүргүүлж ажилласан.

2. Нэг хаяган дээр 10 дээш оршин суугчидтай аймгийн төвийн гэр хорооллын 7 багийн 140 өрхийн 470 иргэний хаягийг багийн дарга нартай хамтран иргэдийн мэдээллийг тулган шалгахад манай аймгийн хэмжээнд зөрчил

илрээгүй байнгын оршин суугчид байсан. Тус аймгийн харьяат ижил овог нэртэй болон 2 регистрийн дугаартай 163 иргэнийн мэдээллийг иргэдийн гар дээрх бичиг баримт, архивын эх нотлох баримтанд тулган шалгахад регистрийн үсэг тоо зөрүүлж бичсэн-88, хүйс зөрүүлж регистрийн дугаар дахин олгосон-42, ижил нэртэй өөр хаягтай-33 иргэний мэдээллийг тус тус шалгаж мэдээллийн сангийн зөрүүг арилгуулахаар хяналтын улсын байцаагчид жагсаалтаар 130 иргэний нэрсийг хүргүүлж дүгнэлт гаргуулж зөрчлийг арилгаж ажилласан. Мөн тухайн аймгаас шилжин явсан боловч шилжилт хөдөлгөөний бүртгэл хийгдээгүй 74 иргэнийг хаягжуулах ажлыг зохион байгуулж дээрх иргэдтэй холбоо барьж 44 хаягжуулсан.

3. УИХ-ын сонгууль, аймаг нийслэл сум дүүргийн сонгуулийн хэсэг байгуулж, хэсгийн төв нутаг дэвсгэр, төвийг зарласан сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2 удаагийн ээлжит сонгуулийн тогтоолыг хүлээн авч нягтлан шалгаж, нэгтгэн улсын бүртгэлийн мэдээллийн санд шивэн баталгаажуулсан.

4. Сонгуулийн эрх бүхий иргэнд хэсэг оноох ажлыг мөн ээлжит шат шатны 2 удаагийн сонгуулийн Сонгогчдын нэрийн жагсаалтанд бичигдсэн тус аймгийн 88 хэсгийн 37640 иргэнд хуулийн хугацаанд хэсэг оноох ажлыг 2 удаа хийж, гүйцэтгэсэн.

5. УИХ, аймаг нийслэл сум дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах 830 гаруй лавлагааг тухай бүрд нь тусгаж, өөрчлөлт оруулсан байдлаар жагсаалтыг сонгуулийн хуульд заасан хугацаанд цаасан хэлбэрээр хоёр удаа хэвлэж, аймгийн 18 сумын 88 сонгуулийн хэсгийн хороодод хүргэж ажилласан.

6. УИХ-ын болон Аймаг нийслэл сум дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулийн санал авах байранд Улсын бүртгэлийн байгууллагыг төлөөлөн ажиллах итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан сургалтыг онлайнаар-2, УБЕГ-ын сургалтын багтай хамтран танхимаар 2 удаа тус тус аймгийн төвд зохион байгуулсан.

7. Шат шатны сонгуулийн сонгогчийн нэрийн жагсаалтай холбоотой өргөдөл гомдол ирээгүй, хуульд заасан чиг үүргийнхээ дагуу сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулж аймгийн сонгуулийн хороо болон сумын улсын бүртгэгч, итгэмжлэгдсэн ажилтнуудыг чиг үүргээр ханган ажилласан.

Сумдын улсын бүртгэгч нарыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллахын зэрэгцээ Есөнбулаг сумын бүртгэлийн үйл ажиллагаанд авч байгаа анхан шатны нотлох баримтыг бүртгэл тус бүрээр шалган зааварчлага өгч ажилласан.

Азийн хөгжлийн банкны төслөөр тус аймгийн 17 сум онлайн сүлжээнд холбогдож, иргэний бүртгэлийн үйл ажиллагааг хөтлөн явуулж эхэлсэнтэй холбоотой цаашид шинэ системийн хэрэглэгчийн гарын авлага, материалыг сумын улсын бүртгэгч нарт хүргүүлж, улсын бүртгэлийн төрөл тус бүрээр программд турших ажлыг улсын бүртгэгч нартай хамтран хийж бүртгэл хөтлөхөд программд тусгах саналаа УБЕГ-ын ИБГ-т хүргүүлж ажилласан. Иргэдэд цар тахалын/ ковед-19/ үед иргэний бүртгэлтэй холбоотой лавлагаа мэдээллээ E-Mongolia-с авах, E-баримт ашиглан төлбөр төлөх талаар мэдээлэл өгч ажиллаж байна.

Долоо. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

1. Иргэд хуулийн этгээдийн Эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой 2020 онд иргэд хуулийн этгээдийн Эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн 3564 мэдүүлэг хүлээн авснаас нотлох баримтын шаардлага хангаагүй 68 мэдүүлгийг буцааж 3496 мэдүүлэг хүсэлтийг хуулийн хугацаанд 100% шийдвэрлэв. Үүнээс газраас бусад үл хөдлөх хөрөнгө анх удаа өмчлөх эрхийн 164, төрөөс хувьчилсан газар өмчлөх эрхийн 171, газар эзэмших ашиглах эрхийн 1207, худалдах худалдан авах гэрээгээр өмчлөгч өөрчлөгдөх 181, бэлэглэх гэрээгээр өмчлөгч өөрчлөгдөх 143, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх 53, хамтран өмчлөгч өөрчлөгдөх 48, албадан дуудлага худалдаагаар өмчлөгч өөрчлөгдөх 1, өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээгээр шинэ бүртгэл үүсэх 96, барьцаат зээлийн гэрээний 1346, барьцаат зээлийн гэрээ дуусгавар болгох 955, лавлагаа хуулбар олгох 147, бүртгэлд өөрчлөлт оруулах 120, гээгдүүлсэн болон гэмтээсэн гэрчилгээ дахин олгох 22, бүртгэл хаах 9, бусад гэрээний 5 бүртгэлийг тус тус хийж гүйцэтгэлээ.

2. Бүртгэлийн үйлчилгээний хураамжаар иргэн, хуулийн этгээдээс 41.915.716 төгрөг, улсын тэмдэгтийн хураамжаар 2.756.825 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны татварын орлого 92.588.912 төгрөг тус бүрийг улсын болон орон нутгийн төсөвт тушаалгаж ажиллалаа.

3. Газар эзэмших ашиглах эрхийн дундын мэдээллийн санд нийт 1560 хүсэлт ирсэнээс нотлох баримтын шаардлага хангаагүй 363 хүсэлтийг татгалзан буцаасан ба 1207 хүсэлтийг хүлээн авч улсын бүртгэлийн Э болон А дугаарыг олгосон байна.

✓ **Мэдээ тайлан:**

1. ЭХЭУБГазарт газар эзэмших ашиглах эрхийн Э дугаар, ePRСпрограма дахь Г дугаарын давхардлын судалгааг 4, цахим мэдээллийн санд оруулсан засвар өөрчлөлтийн тайланг 5 удаа, хууль хяналтын байгууллагаар шалгагдаж буй хэрэг маргааны судалгааг 1 удаа тогтсон хугацаанд ЭХЭБГазарт хүргүүлсэн.

2. Бүртгэлийн тоон мэдээг сараар, ажлын гүйцэтгэлийн тайланг сар, улирал, хагас бүтэн жилээр, үнэт цаасны тайланг сараар, орлогын тайланг сараар, улсын тэмдэгтийн хураамжийн тайланг улирлаар тухай бүр хугацаанд нь нэгтгэн тайлагнасан.

3. Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээний 566ш, газар өмчлөх эрхийн гэрчилгээний 390ш, лавлагааны 145ш үнэт цаасыг ашигласан ба иргэд хуулийн этгээдэд олгосон байна.

✓ **Мэдээлэл сурталчилгааны чиглэлээр**

1. Аймгийн хэмжээнд нийт 8000 гаруй иргэн хуулийн этгээдэд биечлэн болон утсаар, онлайн хэлбэрээр бүртгэлийн хууль тогтоомж, ажил үйлчилгээний талаар мэдээлэл өгч гарын авлага материал хүргэж ажиллалаа.

2. Аймгийн ГХБХБГазар, ШШГГазар, тойргийн нотариатууд, Хаан, Хас, Төрийн банк, ББСБ-ууд, Татварын хэлтэс, Сумдын тамгын газрын дарга нартай тогтмол хамтран ажиллаж мэдээлэл сурталчилгаа хийж ажилласан.

3. Аймгийн хуулийн байгууллагуудын дунд болон төрийн байгууллагуудын дунд зохиогдсон нээлттэй хаалганы өдөрт 2 удаа оролцож иргэд хуулийн этгээдэд мэдээлэл сурталчилгаа хийлээ.

4. Бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөний дагуу 11 сарын 9-11 өдрүүдэд Шарга, Төгрөг, Тонхил сумдад 1 улсын бүртгэгч томилолтоор ажиллаж эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг орон нутагт үзүүлж 69 иргэн хуулийн этгээдийн мэдүүлэг хүсэлт хүлээн авч, үүнээс 25 иргэний мэдүүлгийг боловсруулж улсын бүртгэлийн гэрчилгээг олгож, 155 иргэн хуулийн этгээдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

✓ **Бусад ажлын мэдээлэл**

1. Цахим сан дахь 450 бүртгэлийн нотлох баримтыг архивын эх баримттай тулган шалгаж цахимжуулалтын явцад буруу цахимжуулсан, бүртгэлийн явцад буруу дутуу боловсруулсан 227 алдаазөрчлийг жагсаалтаар гаргасан.

2. Цахим сан дахь алдаатай 184 бүртгэлийн мэдээлэл нотлох баримтанд хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үндэслэн засвар өөрчлөлт оруулж залруулсан.

3. ЭХЭУБГазраас ирүүлсэн "Эд хөрөнгийн эрхийнбүртгэл хөтлөх үйл ажиллагааны заавар"-ын төсөлд 12 саналыг гаргаж хүргүүлсэн.

4. Аймгийн ГХБХБГазартай газар өмчлөл эзэмшил ашиглалт түүний нотлох баримтууд холбогдох хууль журмуудад нийцсэн байх, хаягжуулалт холбогдох хууль журам, тогтоол шийдвэрт нийцсэн байх талаар, ШШГГазартай үл хөдлөх хөрөнгийн захиран зарцуулах эрх түдгэлзүүлэх, сэргээх, иргэн хуулийн этгээдийн өмчлөх эрхтэй холбогдох лавлагаа мэдээлэл солилцох хууль журмыг хэрхэн хэрэгжүүлэх талаар, аймгийн тойргийн нотариатуудтай гэрээ хэлцэл түүний эрх зүйн зохицуулалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар, Хаан,Хас, Төрийн банк, Банк бус санхүүгийн байгууллагуудтай барьцааны эрхийн бүртгэл, лавлагаа мэдээлэлтэй холбогдох хууль журам, тушаал шийдвэрийн талаар,Татварын хэлтэстэйүл хөдлөх эд хөрөнгийн өмчлөлтэй холбогдох лавлагаа мэдээлэл солилцох хууль,журмын талаар,сумдын тамгын газрын дарга нартай гэрээ хэлцэл, иргэний баримт бичиггэрчлэхтэй холбогдох хууль журмуудыг тухай бүр танилцуулж мэдээлж,тогтмол хамтран ажиллаж, мэдээлэл солилцож, зөвлөлдөж ажиллалаа.

✓ **Албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт**

1. Хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн 245 албан бичгийн дагуу 208 иргэн хуулийн этгээдийн эд хөрөнгө өмчлөлтэй холбоотой лавлагаа олгож, 2 шүүхийн шийдвэрийн дагуу архивын нотлох баримтын хуулбар гаргаж, 84 үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрх түдгэлзүүлсэн тусгай тэмдэглэл бүртгэж, 28 эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг сэргээсэн бүртгэл хийж, МИК-ийн 7 албан бичгийн дагуу 25 үл хөдлөх хөрөнгийн хөрөнгийн багц дахьтусгай тэмдэглэл бүртгэж, бусад төрийн байгууллагын албан бичгийн дагуу 7 лавлагаа мэдээлэл гаргаж тухай бүр хугацаанд нь хариу хүргүүлж ажиллалаа.

2. Иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн эд хөрөнгө өмчлөх эрхтэй холбоотой 2 өргөдөл хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж хариу өгч ажиллалаа

Найм. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн 386 бүртгэл хийсэн. Үүнд: Шинээр 67 аж ахуйн нэгж, хуулийн этгээд бүртгүүлсэнээс ХХК-50, Сан-1,Үйлдвэрчний эвлэлийн байгууллага-1, Төрийн байгуулага, албан газар -1, Төрийн бус байгууллага –6,Улсын төсөвт үйлдвэрийн газар – 1, Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар – 1, нөхөрлөл– 6 байна.

1. Нэмэлт өөрчлөлт эцсийн өмчлөгчөөр бүртгэсэн 70,
2. эцсийн өмчлөгчөөр бүртгэж гэрчилгээ дахин олголт 241,
3. Хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газрын улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгосон- 8

Орон нутгийн төсвийн дансанд 14,412,000 төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна. Тус аймагт бүртгэлтэй 1218 хувийн хэрэг архивт байрлаж байна. 192 нь төрийн байгууллага улсын төсөвт, ААТҮГ эцсийн өмчлөгчөөр бүртгэхгүй учир 1026 аж ахуйн нэгжийг эцсийн өмчлөгчөөр бүртгэлд хамруулахаас эцсийн өмчлөгчөөр бүртгүүлсэн 378 аж ахуйн нэгж эцсийн өмчлөгчөө мэдүүлж 36.9%-тай байна.

Бүртгэлийн тоон мэдээг сараар, ажлын гүйцэтгэлийн тайланг сар, хагас бүтэн жилээр, үнэт цаасны тайланг, сараар орлогын мэдээг сараар, улсын тэмдэгтийн хураамжийн тайланг улиралаар тухай бүр хугацаанд нь нэгтгэн тайлагнасан. Алтайн сүрлэг нуруу ХХК-ийн хувьцаа эзэмшигч Н.Батболдын нэхэмжлэлтэй захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан хэрэг маргаанд шүүхэд хариу тайлбар гарган өгч шүүх хуралдаанд оролцсон. Шүүх хуралдаанаар нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

ХЭБГ-аас зохион байгуулсан 3 удаагийн онлайн сургалтанд хамрагдсан.

Ес. АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:

9.1. Эд хөрөнгийн бүртгэлийн архив:

Эд хөрөнгийн архивт шинээр бүртгэсэн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн 234, газар өмчлөх эрхийн 158 хувийн хэрэг, газар эзэмших эрхийн 349 хувийн хэрэг газар ашиглах эрхийн 5 нийт 746 хувийн хэрэг архивт хүлээн авч бүртгэл хөтлөн байрлуулсан.

3276 ширхэг хувийн хэргийн эх нотлох баримтыг бүртгэгч нараас хүлээн авч хувийн хэрэг тус бүрт байрлуулсан.

2020 оны 12 сарын 01-ны байдлаар тус архивт газраас бусад үл хөдлөх хөрөнгийн 4795 хувийн хэрэг, газар өмчлөх эрхийн бүртгэлийн 4581 хувийн хэрэг, газар эзэмших эрхийн бүртгэлийн 390 хувийн хэрэг газар ашиглах эрхийн 5 нийт 9766 хувийн хэрэг хадгалагдаж байна.

Одоогийн байдлаар тус архивт байнга хадгалах бүртгэлийн дэвтэр 203 х/н, түр хадгадагдах 142 дэвтэр хадгалагдаж байна.

9.2. Хуулийн этгээдийн бүртгэлийн архив:

Хуулийн этгээдийн архивт анхны бүртгэлийн 68 ширхэг хувийн хэрэг шинээр хүлээн авч, бүртгэн архивт байрлуулсан. Үүнд. ОНӨААТҮГ 1, Нөхөрлөл 6, ХХК-52, УТҮГ 1, ҮЭБ 1 Төрийн бус байгууллага 6, сан 1 тус тус бүртгэгдсэн байна. Нийт 1246 хувийн хэрэгтэй болсон байна / Хоршоо 114, нөхөрлөл 60, ХХК 678, ТӨХХК 1, ХК 2, ХМХ 3, ХЗХ 12, ББСБ 1, БСБ 1, Сан 4, Шашны байгууллага 3, ҮЭБ 8, ОНӨААТҮГ 14, ТӨААТҮГ 1, ТББ 136, УТҮГ 180 /.

Иргэн хуулийн этгээдэд хуулбар болон лавлагааг 32 ширхэгийг олгосон. Хуулийн этгээдийн хувийн хэрэгт 269 ширхэг эх нотлох баримтыг хүлээн авсан.

9.3. Иргэний бүртгэлийн архив:

Тус архивт 12 сарын байдлаар 6191 ширхэг ИУБ маягт хүлээн авч цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан сан тус бүрт байрлуулсан.

2020 онд шилжин явсан 47 иргэний хувийн хэргийг архивын сангаас татан авч харьяа газарт нь хүргүүлсэн. Архивын санд хувийн хэргийг тоолох явцад өөр аймгийн харьяат 1258 иргэний хувийн хэргийг сангаас ялган авч харьяа газарт нь хүргүүлсэн болно.

Шилжин ирсэн 254 иргэний хувийн хэргийг хууль журмын дагуу хүлээн авч бүртгэл хөтлөн цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан архивт байрлуулсан. 16 нас хүрч шинээр иргэний үнэмлэх авсан 823 иргэний хувийн хэргийг цагаан толгой үсгийн дарааллаар галиглан хувийн хэргийн нэгдсэн санд байрлуулсан. 2019 онд бүргэгдсэн ИГБББ-ийн анхан шатны баримт болон бүртгэлийн дэвтэр 182 хадгаламжийн нэгжийг хүлээн авч ИГБББ-ийн санд байрлуулсан. ИГБББ санд нийт 1190 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна.

Иргэний баримтын архивт тооллого явуулж дууссан.” Хувийн хэргийн сан”д нийт 41750 иргэний 163034 ширхэг маягт. Үүнээс: ИУБ-31 маягт 50245, ХААТР-21 маягт 53474, ХААТР-1 маягт -22846, маягт-7 9457, ХААТР-11 маягт 14457, ХААТР-12 маягт 379, ХААТР-13 маягт 2298, ХААТР-14 маягт 516, ХААТР-15 маягт 8778, ХААТР-16 маягт 252, ХААТР-25 маягт 188, ИБЗ-1 маягт 272 ширхэг тус тус хадгалагдаж байна.

“ХААТР-11 санд” 2005-2020 оны 19347 иргэний ИУБ11 маягт 19284, ИУБ-12 маягт 321, ИУБ13 маягт 476, ИУБ14 маягт 1172, ИУБ25 маягт 16, ИЗБ-1 маягт 214 ширхэг нийт 21483 ширхэг хаатр маягт хадгалагдаж байна.

“ХААТР-18 санд” 8690 иргэний хувийн хэрэг байна.

Өнөөдрийн байдлаар иргэний бүртгэлийн архивт нийт 71923 иргэний хувийн хэрэг хадгалагдаж байна.

Мөн 179 иргэний хүсэлтээр архивын баримтнаас төрөлт, гэрлэлт, нас баралтын лавлагаа шүүсэн.

9.4. Бусад

Иргэн, Эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн архивын хувийн хэргийн мэдээг сар бүр гаргаж УБТА-т хүргүүлсэн.

УБЕГ-ын УБТАрхиваас ирсэн чиглэлийн дагуу устгах бичгийн түүвэр жагсаалт үйлдэн байгууллагын БНШК-ын хурлаар оруулан хэлэлцүүлж санал хүргүүлсэн. Архивын баримтын тоо бүртгэлийг хөтлөж байнга, түр хадгалах хадгаламжийн нэгжийн жагсаалт, ХХНЖ зэргийг гарган БНШК-ын хурлаар батлуулав. 2019 онд устгахаар ялгасан баримтуудыг УБЕГ-аас ирсэн зөвлөмжийн дагуу устгасан.

Арав. БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Тайлангийн хугацаанд Хяналт шалгалтын ажлын 11 заалт бүхий төлөвлөгөөг гаргаж, хэлтсийн даргаар батлуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт шалгалтыг 19 удаа, төлөвлөгөөт бус шалгалт 4 удаа, гүйцэтгэлийн шалгалтыг 1 удаа, өргөдөл санал гомдлын мөрөөр 281 удаа шалгалт хийж шалгалтын дүнг илтгэх хуудсын хамт Хэлтсийн дарга, мөн Хяналт шалгалтын газарт тухай бүр нь хүргүүлсэн.

Иргэний улсын бүртгэлийн 7659 бүртгэлд хяналт тавьж, хяналт шалгалтаар илэрсэн 491 бүртгэлийн зөрчлийг арилгаж ажиллалаа. Төрсний 99, гэрлэсний 27, гэрлэлт цуцалсны 3, үрчлэлт 3, овог, эцгийн нэр, нэр өөрчилсөн 10, эцэг тогтоосон

5, нас барсны 19, иргэний үнэмлэхийн 842, биеийн давхцахгүй өгөгдлийн 14, регистрийн дугаарын 172, шилжилт хөдөлгөөний 6465 бүртгэлийг шалгалаа.

Хяналт шалгалтын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу иргэний шилжин суурьших хөдөлгөөний 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрүүдийн нийт 763 бүртгэлд 2 удаа шалгалт хийж, эх нотлох баримтыг цахимаар татан авч шалгахад 141 бүртгэлийн нотлох баримтын бүрдэл шаардлага хангахгүй, Багийн засаг даргын албан тоотоор бүртгэл хийсэн байсныг холбогдох сумын бүртгэгчид чиглэл өгч нөхөж бүрдүүлүүлэн, биелэлтийг шалгаж, зөрчлийг арилгаж ажилласан. Мөн 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс 08 дугаар сарын 14-ний өдрийг дуусталх хугацааны 451 бүртгэлд 7 хоног тутамд эх нотлох баримтыг цахимаар татан авч, төлөвлөгөөт бус шалгалт хийлээ. Шилжилт хөдөлгөөний ИУБ22 маягтыг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд бүртгэл хаагдахаас өмнө оруулаагүй байсан Жаргалан сумын 1, Хөхморьт сумын 7 бүртгэлийг цахим санд оруулах тухай дүгнэлт гаргаж зөрчлийг арилгасан. 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 12 дугаар сар хүртэлх хугацааны иргэний шилжилт хөдөлгөөний нийт 4488 бүртгэлийг цахим сантай тулган шалгахад шилжиж очсон газраа бүртгүүлээгүй зөрчилтэй 26 иргэн байсан.

Регистрийн дугаар давхардсан 162 иргэний бүртгэлийг архив дахь холбогдох бүртгэл, цахим мэдээллийн сантай тулган шалгаж, гэрлэсний бүртгэлд буруу регистрийн дугаараар бүртгэгдсэн 16 бүртгэлд регистрийн дугаарыг залруулсан, төрсний бүртгэлд 2 регистрийн дугаараар давхар бүртгэгдсэн 46 иргэний регистрийн дугаарыг хүчингүй болгож шийдвэрлэсэн.

УИХ болон орон нутгийн ИТХ-ын сонгуультай холбогдуулан иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох, сонгогчдын хэсэг оноолт, сонгогч шилжилт, сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах, сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан.

Сонгогч шилжилт хөдөлгөөнд бүртгүүлсэн нийт 850 иргэний нотлох баримтуудын бүрдүүлбэрийг нэгбүрчлэн хянаж шалган, хянасан тухай тэмдэглэж ажилласан. Сонгогч шилжилтийн 805 лавлагаа, түр хасав тэмдэглэгээ сэргээгдсэн өөрчлөлт хийсэн 33, иргэний улсын бүртгэлтэй холбоотой өөрчлөлт 12 хэвлэгдсэн лавлагааг давхар хянаж, гарын үсэг зурж ажилласан.

Сонгогч шилжилтээр бүртгүүлсэн 1 бүртгэлийн шилжиж очсон хэсгийг дүгнэлт гаргаж залруулсан.

Мөн итгэмжлэгдсэн ажилтнууд сонгогчдын нэрийн жагсаалтад иргэний бүртгэлийн өөрчлөлтийн лавлагааг оруулах явцад гарсан 25 алдааг залруулуулж бүртгүүлсэн.

2020 оны 05 дугаар сарын 26-ны өдөр тус аймагт бүртгэлтэй нийт 37842 сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх үйл ажилаагаанд хяналт тавьж ажилласан.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг хувилж, олшруулахгүй байх, хууль зөрчсөн үйлдэл гаргахгүй байхыг анхааруулан, улсын байцаагчийн мэдэгдэл үйлдэж, сумын Сонгуулийн хороодод хүргүүлсэн.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 192 бүртгэлд хяналт тавьж, 136 бүртгэлийн зөрчлийг арилгаж ажиллалаа.

ХШГ-аас ирүүлсэн хяналтын ахлах байцаагчийн албан шаардлагын дагуу улсын бүртгэлийн Г-0508000064 дугаартай газрын өмчлөх эрхийг хуулийн этгээдийн нэр

дээр шилжүүлэн бүртгэсэн бүртгэлийн тухайн мэдүүлгээр бүртгэсэн үйлчилгээг хүчингүй болгосон.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын цахимжилтын явцад 115 хөрөнгийн өмчлөгч, хаяг, барьцаалагчийг буруу сонгож оруулсан, зурган мэдээлэл ороогүй, бүртгэлийн төрөл, огноог буруу сонгож оруулсан, үнэ бичээгүй, , үйлчилгээний төрлийг буруу сонгож цахимжуулсан, дутуу цахимжуулсан, газрын нэгж талбарын дугааргүй бүртгэсэн, бүртгэлийн өмчлөгчийн нэр, регистрийн дугаар буруу бүртгэгдсэн бүртгэлийн хөрөнгийн хэмжээг буруу бүртгэсэн, үл хөдлөх хөрөнгийн хамгийн сүүлчийн үйлчилгээнд дутуу гүйцэтгэлтэй барилгыг 100%-ийн гүйцэтгэлтэй гэж бүртгэснийг тус тус залруулсан.

бш үл хөдлөх хөрөнгийн гээгдүүлсэн гэрчилгээг хүчингүйд тооцсон хяналтын байцаагчийн дүгнэлт гаргаж шийдвэрлэсэн.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 110 бүртгэлд хяналт тавьж, 33 бүртгэлийн зөрчлийг арилгаж ажилласан. Бүртгэлийн хувийн хэргийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн сантай тулган шалгахад 12 хуулийн этгээдийн хувийн хэргийн хэргийн дугаар буруу байсныг залруулсан. Мандал голомт ХХК-ийн хувьцаа эзэмшигч гишүүдийн эзэмших хувьцааны хувийг сольж бүртгэсэн, нотлох баримт зөрүүтэй байхад бүртгэл хийсэн, Иргэдээс ирүүлсэн 62 өргөдөл, материалыг хүлээн авч, 57 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Үүнд: 4 өргөдлийн хариуг албан бичгээр, 53 өргөдлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргаж шийдвэрлэсэн байна. 5 өргөдөл шийдвэрлэх шатандаа буюу хугацаа болоогүй байна.

Улсын бүртгэлийн зөрчил арилгах, засвар өөрчлөлт оруулах, бүртгэл хүчингүй болгох, регистрийн дугаар өөрчлөх, цахим санд бүртгэл хийх, бүртгэл сэргээн тогтоосон 152 дүгнэлт гаргаж, дүгнэлтээр 323 бүртгэлийн зөрчлийг арилгасан. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 108, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 14, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 30 дүгнэлт гаргасан. Үүнд: Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд алдаатай бүртгэсэн зөрчлийг арилгасан 27, иргэний улсын бүртгэлд засвар өөрчлөлт оруулах тухай 33, бүртгэл хүчингүй болгох тухай 12, иргэний улсын бүртгэлийн зөрчил арилгасан 10, регистрийн дугаар өөрчилж дахин олгосон 6, регистрийн дугаар хүчингүй болгосон 3, бүртгэл сэргээн тогтоосон 1, сонгогч шилжсэн бүртгэлийг залруулсан 1, иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд хуулийн хугацаанд оруулаагүй шилжилт хөдөлгөөний бүртгэлийг цахим санд бүртгэх тухай 2, иргэний үнэмлэх хүчингүй болгосон 13, Хуулийн этгээдийн улсын бүртгэлд засвар өөрчлөлт оруулах 9, хуулийн этгээдийн бүртгэлийн зөрчил арилгасан 5, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд засвар өөрчлөлт оруулах 24, эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсон 6 гэх мэт дүгнэлт гаргаж, хяналт шалгалтын газраар хянуулж шийдвэрлэсэн.

Бүртгэл хөтлөхөд гарч буй алдаа зөрчлийг давтан гаргуулахгүй байх, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор сумдын бүртгэгч нарт онлайнаар 2 удаа, танхимаар 1 удаа сургалт хийж, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Биеийн давхцахгүй бүртгэлийн алдаа гаргасан Алтай, Баян-Уул, Бигэр, Хөхморьт, Тайшир, Дэлгэр, Бугат, Чандмань, Төгрөг, Цогт, Есөнбулаг, Халиун сумдын бүртгэгч нар, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх явцад алдаа гаргасан бүртгэгч

нараас тайлбар авч, зөрчлийг арилган шийдвэрлэж, алдааг давтан гаргахгүй байхыг анхааруулсан. Шилжилт хөдөлгөөний бүртгэлийн ИУБ 22 маягтыг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд хуулийн хугацаанд оруулаагүй алдаа гаргасан 8 бүртгэлд холбогдох бүртгэгчээс тайлбар авч, зөрчлийг арилгасан.

Төгрөг, Шарга сумдын бүртгэлийн үйл ажиллагаанд шалгалт хийх явцад илэрсэн 26 зөрчилд зөрчлийн тэмдэглэл үйлдэж, зөрчлийг арилгуулахаар хариуцсан бүртгэгчид хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллалаа. Алдаа зөрчлийн судалгааг гаргаж, нэг төрлийн алдааг давтан гаргуулахгүй байх тал дээр анхаарч ажиллаж байна.

Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авч, прокурорын байгууллагын гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд тухай бүрд нь бүртгүүлэн, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулж, материалыг аймгийн Прокурорын газрын хяналтын прокурорт 7 хоног тутамд хянуулан ажиллаж байна. Тайлангийн хугацаанд улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн 605 хүн, 1 хуулийн этгээдэд нийт 14 255 000 төгрөгийн торгох шийтгэл ногдуулсан.

УИХ-ын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж, 5 дугаар тойргийн 76-р хэсгийн хорооны сонгогчдын нэрийн жагсаалтыг хувилж олшруулсан гэх гомдол мэдээллийн дагуу захиргааны зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг прокурорын хяналтан дор явуулж Чандмань сумын 76-р хэсгийн хорооны гишүүд, тухайн хэсгийн хорооны дарга, сумын сонгуулийн хорооны дарга нарын 7 хүнээс гэрчийн мэдүүлэг авав. Шалгалтаар тус хэсгийн хороонд мэдээллийн технологийн даамлаар ажилласан тус сумын Өлзийбулаг багийн эмч ажилтай Дамчийн Бадамцэцэг нь сонгуулийн санал авах ажиллагаа дууссаны дараа өөрийн ажиллаж байсан 76-р хэсгийн хорооны сонгогчдын нэрийн жагсаалтыг хувилж олшруулсан болох нь тогтоогдсон. Дээрх хууль зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, цаашид давтан гаргуулахгүй байхыг анхааруулж Чандмань сумын ИТХ-ын тэргүүлэгчдэд улсын байцаагчийн мэдэгдэл хүргүүлсэн.

Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 1, хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой 1 хэрэг маргаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон ажилласан. Уг 2 хэрэг хэрэгсэхгүй болж шийдвэрлэгдсэн..

Хяналт шалгалтын ажлын статистик тоон мэдээг батлагдсан хүснэгтийн дагуу тухайн сарын 25-ны өдрөөр тасалбар болгон гаргаж, Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн. Үнэт цаасны зарцуулалтын тайланг санхүүд гарган өгч, хувийг УБЕГ-ын Тамгын газарт заасан хугацаанд хүргүүлсэн. Энэ хугацаанд шийтгэлийн хуудас 606, дүгнэлтийн баланк 310, улсын байцаагчийн мэдэгдлийн баланк 39-ийг тус тус зарцуулсан бөгөөд албан шаардлага, актын баланк зарцуулагдаагүй байна. Мөн зөрчлийг хяалбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн ажиллагааны мэдээ, материалыг тухай бүр нь аймгийн Прокурорын газарт хүргүүлж, хянуулан ажилласан.

УБЕГ-аас зохион байгуулсан Сонгуулийн хуультай холбоотой сургалтанд танхимаар 2 удаа, онлайнаар 2 удаа хамрагдсан. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас зохион байгуулсан сургалтанд онлайнаар 1 удаа, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн эцсийн өмчлөгч бүртгэх чиглэл өгсөн сургалтанд онлайнаар 1 удаа хамрагдсан.

2020 оны 05 дугаар сард УБЕГ-ын Хяналт шалгалтын газраас зохион байгуулсан “Улсын байцаагчийн дүгнэлт үйлдэх арга зүй” сэдэвт 3 өдрийн цахим сургалтанд оролцож, иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр дүгнэлт үйлдэх арга зүйд суралцан, даалгаварт өгсөн 3 бүртгэлийн чиглэлээр дүгнэлт үйлдэж, даалгаврыг маш сайн гүйцэтгэсэн үнэлгээ авсан.

УБЕГ-ын ХШГ, аймгийн Прокурорын газраас ирүүлсэн 15 хариутай бичгийн хариуг заасан хугацаанд нь гүйцэтгэн, хүргүүлж ажиллалаа.

Арван нэг. САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

11.1. Төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл:

2020 оны 12 сарын 10-ны өдрийн байдлаар тус хэлтэс нь 2020 онд бүртгэлийн үйлчилгээний орлого 90 сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс 90.5 сая төгрөг оруулж төлөвлөгөөний биелэлт 100.5% -тай байна.

Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

2020.12.10 / өссөн
дүнгээр/

/
Сая төг /

Нэр, төрөл	2019 оны төлөвлөгөө	2019 оны гүйцэтгэл	Хувь	2020 оны төлөвлөгөө	2020 оны Гүйцэтгэл	Хувь
Үйлчилгээний орлого	115.0	96,9	84.2%	90.0	90.5	100.5%

11.2. Төсөв, санхүү

2020 онд урсгал үйл ажиллагааны санхүүжилт өмнөх оноос 18,512,100.00 төгрөгөөр өссөн нь албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна. 2020 оны 12 сарын 10-ны байдлаар УБЕГ-с 482,497,600.00 төгрөгийн төсвийн урсгал зардлын санхүүжилт авч, батлагдсан төсөвт зардлыг зориулалтын дагуу зарцуулж ажилласан.

11.3. Төсвийн гүйцэтгэл, зарцуулалт /2020 оны 12-р сарын 10-ны өдрийн байдлаар/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	482,497,600.00	482,497,600.00	-
Улсын төсвөөс санхүүжих	482,497,600.00	482,497,600.00	-
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	482,997,600.00	434,394,217.00	48,603,383.00
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	405,269,600.00	364,061,700.00	41,207,900.00
Үндсэн цалин	327,324,200.00	291,803,753.00	35,520,447.00

Нэмэгдэл	69,103,400.00	65,048,127.00	4,055,273.00
Унаа хоолны хөнгөлөлт	8,842,000.00	7,209,820.00	1,632,180.00
Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгал	51,143,100.00	45,215,983.00	5,927,117.00
Нийгмийн даатгалын шимтгэл	34,797,000.00	31,357,118.00	3,439,882.00
Тэтгэмжийн даатгал	4,086,500.00	3,701,706.00	384,794.00
ҮОМШ-ний даатгал	3,269,200.00	2,897,528.00	371,672.00
Ажилгүйдлийн даатгал	817,300.00	669,661.00	147,639.00
Эрүүл мэндийн даатгал	8,173,100.00	6,589,970.00	1,583,130.00
Байр ашиглалттай холбоотой зардал	6,143,100.00	6,143,100.00	-
Гэрэл, цахилгаан	21,300.00	21,300.00	-
Түлш, халаалт	303,000.00	303,000.00	-
Цэвэр, бохирус	20,000.00	20,000.00	-
Байрны түрээс	5,798,800.00	5,798,800.00	-
Хангамж, бараа материалын зардал	12,245,100.00	11,948,634.00	296,466.00
Бичиг хэрэг	6,115,200.00	5,944,260.00	170,940.00
Тээвэр, шатахуун	1,594,200.00	1,594,200.00	-
Шуудан, холбоо, интернэт	2,668,500.00	2,579,974.00	88,526.00
Хог хаягдал зайлуулах, хортон	37,000.00	0	37,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх,	1,830,200.00	1,830,200.00	-
Эд хогшил, урсгал засварын зар	3,062,300.00	3,062,300.00	-
Багаж, техник, хэрэгсэл	1,595,500.00	1,595,500.00	-
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	766,800.00	766,800.00	-
Урсгал засвар	700,000.00	700,000.00	-
Томилолт, зочнызардал	342,000.00	342,000.00	-
Дотоод албан томилолт	342,000.00	342,000.00	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	754,000.00	754,000.00	-
Бусад нийтлэг АҮТХураамж	492,000.00	492,000.00	-
Аудит бат, зэрэглэл тогтоох	0	0	-
Даатгалын Үйлчилгээ	120,000.00	120,000.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	120,000.00	-
Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00	-
Барааүйлчилгээнийбусадзарда	1,664,800.00	686,500.00	978,300.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,164,800.00	686,500.00	478,300.00
Холбооны суваг ашигласны хөлс	1,980,000.00	1,980,000.00	-

Бусад нийтлэг АҮТХураамж	1,980,000.00	1,980,000.00	-
Бусад урсгал шилжүүлэг	393,600.00	200,000.00	193,600.00
Нэг удаагийн тэтгэмж, шаг/урам	393,600.00	200,000.00	193,600.00
Харилцах дансны оны эхний үлдэгдэл			0
Харилцах дансны оны эцсийн үлдэгдэл			48,603,383.00



Орон нутгийн өмчийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 199 дүгээр албан бичгийг үндэслэж Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны 1, 2 дугаар сарын түрээсийн төлбөрийг чөлөөлөх хүсэлтийг зөвшөөрсөн болно

ДАРГА  Ч.БАТ-ЭРДЭНЭ

Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах журмыг баримталж ажилласан бөгөөд Төсвийн гүйцэтгэл, зарцуулалтын хувьд 2020 оны 12-р сарын 10-ны өдрийн байдлаар цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлууд дээр хэмнэлттэй харагдаж байгаа нь албан хаагчдын 12 дугаар сарын цалин бодогдоогүй байгаатай холбоотой.

Тайлант хугацаанд түрээслэгч байхгүй түрээсийн орлого болон туслах үйл ажиллагааны орлого олоогүй боловч тус хэлтэс нь Аймгийн ЗДТГазрын 3-р байранд түрээсээр үйл ажиллагаа явуулдаг ба 2020 онд түрээсийн төлбөртсар болгон 1,000,000.00 төгрөг жилд 12,000,000.00 төгрөг

төлөх гэрээтэй байсан боловч 3-р сард гэрээгээ шинэчлэн хийж, тус сараас эхлэн сард 579,875 төгрөг төлөхөөр гэрээ байгуулсан.

Мөн 2020 оны 1 болон 2 дугаар сарын байрны түрээсийн төлбөрөөс 2,000,000.00 төгрөгийг чөлөөлүүлж, тус онд байрны түрээсийн төлбөрт 5,798,800.00 төгрөг төлж 6,201,200.00 төгрөгийн хэмнэлт гарган ажилласан байна.

11.4. Өглөг, авлагын талаар:

Төсвийн гүйцэтгэл, зарцуулалтын хувьд баталсан төсвийн хуваарийн дагуу явж байгаа боловч зарим зардлуудад хувиарласан төсөв хүрэлцэхгүй байсан учир тооцоо, судалгаа гаргаж УБЕГ-н Санхүү төлөвлөлтийн газарт хүргүүлэн төсвийн хуваарьт 3 удаа өөрчлөлт оруулан зарим зардлуудыг өөр эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэх ажлуудыг хийж өглөг, авлага үүсгэхгүй ажиллалаа.

11.5. Нэмэлт санхүүжилтын талаар:

УБЕГазраас 2020 оны УИХ-н сонгуультай холбоотойгоор 87,369,300.00 төгрөг, Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн ИТХ-н сонгуультай холбоотойгоор 64,316,100.00 төгрөг нийт 151,685,400.00 төгрөгийн нэмэлт санхүүжилт авч дараах байдлаар зориулалтын дагуу нийт 151,685,400.00 төгрөгийг зарцуулсан. Үүнд:

Зардлын ангилал	Мөнгөн дүн /төгрөгөөр/
Итгэмжлэгдсэн ажилтнуудын урамшуулалд	74,760,000.00
Албан хаагчдын урамшуулалд	23,145,000.00
Томилолтын зардалд	27,253,000.00

Тоног төхөөрөмжийн тээвэрлэлт /УБ, Аймаг хооронд/	11,200,000.00
Бичиг хэрэг	6,333,200.00
Сонгогчийн нэрийн жагсаалт хүргэх шатахууны зардал	5,145,800.00
Сургалтын бусад зардал	3,328,400.00
Шуурхай багийн зардал	520,000.00
НИЙТ ДҮН	151,685,400.00

11.6. Аудит, хяналт шалгалтын байгууллагаас хийсэн шалгалтаар зөрчил дутагдалгүй ажилласан байдал, НББОУС, холбогдох хууль тогтоомж, заавар, журам мөрдөж ажилласан байдал

Санхүүгийн ил тод байдлыг хангах зорилгоор тус хэлтэс нь Говь-Алтай аймгийн Төрийн аудитын байгууллагаар санхүүгийн аудит хийлгэж “**ЗӨРЧИЛГҮЙ**” гэсэн дүгнэлттэй гарсан. зөвлөмж, акт, албан шаардлага өгөөгүй болно.

Мөн 2020 оны УИХ, Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн ИТХ-н сонгуулийн баримтад аудит хийлгэж ямар нэгэн зөрчилгүй ажилласан бөгөөд тайлант хугацаанд санхүүгийн баримтад зөрчил илрээгүй ба аудитын газраас санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөмж, акт, албан шаардлага өгөөгүй болно.

11.7. Үндсэн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хөрөнгө оруулалт.

2020 оны эхэнд барилга, авто машин, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, програм хангамж гэсэн 5-н бүлгийн 260,371,757.82 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байсан бөгөөд 2020.12.10-ны байдлаар 256,668,470.69 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Тус хэлтэс нь орон сууцны 3 өрөө байртай.

Мөн тус хэлтсийн 2019 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогоор ашиглалтын хугацаа дуусч, ашиглах боломжгүй болсон нийт 14-н нэр төрлийн 8,144,843,13 төгрөгийн хөрөнгийг актлуулах саналыг 2020 оны 3-р сарын 23-ны өдрийн №256 тоот албан бичгээр байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн 2019 оны №04 тоо хурлын тэмдэглэл, дүгнэлтийг УБЕГ-н Санхүү төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.

Үүний дагуу ТӨБЗГазраас 10-н нэр төрлийн 7,482,033.13 төгрөгийн үндсэн хөрөнгийн актлах шийдвэр гарсан тул байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2020.09.08-ны өдөр №01 тоот хурлын тэмдэглэл, дүгнэлтийг үндэслэн хэлтсийн



даргын 2020.09.09-ны А/19 тоот тушаалын дагуу үндсэн хөрөнгийн акталж, устгасан тайланг 2020.09.14-ны №892 тоот албан бичгээр УБЕГ-н Санхүү төлөвлөлтийн газарт, №893 тоот албан бичгээр ТӨБЗГазарт тус тус хүргүүлж ажилласан.

Мөн 2020.03.23-ны №255 тоот албан бичгээр үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох саналыг тус хэлтсийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2019.12.20-ны №02 тоот хурлын тэмдэглэл, дүгнэлт хүргүүлсэн боловч 2020.12.10-ны өдрийн байдлаар ямар нэгэн шийдвэр гарч ирээгүй байна.

Хэлтсийн албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг хүн тус бүрээр хөтөлж байна.

УБЕГ-с 2020 онд 1,450,000.00 төгрөгийн зургын аппарат 1 ширхэг, 1,638,846.00 төгрөгийн компьютер 1 ширхэг, нийт 3,088,846 төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэлд тусгасан.

11.8. Тайлан мэдээ

2020 оны жилийнэцсийн байдлаар тус хэлтэс сар, улирал, өдөр тутам гаргах тайлан, мэдээг хугацаанд нь гаргаж харъяалагдах байгууллагад хүргүүлж ажилласан.

Үүнд:

1. Тус хэлтсийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг сарын бүрийн 2-ны өдрийн дотор Төрийн сангийн хэлтсээр баталгаажуулан Санхүү төлөвлөлтийн газрын нягтлан бодогч А.Наранцэцэгт a.narantsetseg@burtgel.gov.mn цахим шуудангаар хүргүүлсэн.

2. Үнэт цаасны тайлан мэдээг сар бүрийн 5-ны өдрийн дотор Санхүү төлөвлөлтийн газрын нягтлан бодогч Ц.Ганчимэгт ts.ganchimeg@burtgel.gov.mn цахим шуудангаар хүргүүлсэн.

3. 2020 оны 1, 2, 3-р улирлын санхүүгийн тайланг дараа сарын 15-ны өдрийн дотор Санхүү төлөвлөлтийн газрын нягтлан бодогч А.Наранцэцэгт a.narantsetseg@burtgel.gov.mn цахим шуудангаар хүргүүлсэн. Хагас жилийн санхүүгийн тайланг Сангийн яамны Э-Тайланд шивж нэгтгүүлсэн.

4. 2021 оны төсвийн төслийг 2020.06.23-ны өдрийн №592 тоот албан бичгээр УБЕГ-н Санхүү төлөвлөлтийн газарт шуудангаар болон uelunujin@burtgel.gov.mn хаягаар тус тус хүргүүлсэн

5. Үйлчилгээний орлогын мэдээг нэгтгэн сар бүрийн 30-нд Санхүү төлөвлөлтийн газрын нягтлан бодогч А.Наранцэцэгт a.narantsetseg@burtgel.gov.mn цахим шуудангаар хүргүүлсэн.

6. Тус хэлтсийн нийгмийн даатгалыншимтгэлийн тайланг сар бүрийн 5-ны дотор бэлтгэн гаргаж Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлсэн.

7. ХХОАТ-н тайланг улирал болгон гарга дараа сарын 15-ны өдрийн дотор Аймгийн Татварын хэлтэст хүргүүлсэн.

11.9. Төсвийн ил тод нээлттэй байх зарчим, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хийсэн ажил

Байгууллагын үйл ажиллагаа болон төсөв, санхүүгийн гүйцэтгэлийг хэлтсийн байрны мэдээллийн самбарт тухай бүр байршуулсан.

Шилэн дансны мэдээллийг 12-р сарын 10-ны байдлаар 133 мэдээлэл хугацаанд нь оруулж, 4 мэдээлэл хугацаа хоцорсон, огт оруулаагүй мэдээлэл байхгүй бөгөөд 2019 оны 4-р улирал, 2020 оны 1, 2, 3-р улирлын мэдээллийг хугацаанд нь илгээсэн бөгөөд 2019 оны жилийн эцсийн мэдээлэл болон хавсаргах файлуудыг хугацаанд нь бүрэн оруулж дуусгасан.

Мөн Аймгийн Төрийн Аудитын газраас 2020 оны 02-р сарын 13-аас- 20-ны өдрүүдэд шилэн дансны хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж уг шалгалтаар зөрчил илрээгүй бөгөөд ямар нэгэн албан шаардлага, зөвлөмж, акт өгөөгүй болно.

11.10. Бараа материалын бүртгэл хөтлөлт, тайлагнасан байдал

- Няравын болон улсын бүртгэгч нарын үнэт цаасны тайланг хугацаанд гаргуулж нярваар нэгтгүүлэн тогтмол хянаж ажилладаг ба Улсын бүртгэгч нараас ирүүлсэн үнэт цаасны тайланд тусгагдсан хүчингүй болсон үнэт цаасыг сар бүр хүчингүй болгосон акт үйлдүүлэн хяналтын улсын байцаагчаар хүчингүй болгуулан ажиллаж байна.

- Аж ахуйн материал, бичиг хэрэг, бэлэн бүтээгдэхүүн, бусад бараа материалын тайланг сар бүр няраваар гаргуулан хяналт тавьж ажиллалаа.

ХЯНАСАН:

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН

ХЭЛТСИЙН ДАРГА

Г.ЧҮЛТЭМЖАМЦ

ТАЙЛАН БИЧСЭН:

АРХИВЧ, МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН

АЖИЛТАН

Э.БААТАРСҮРЭН